



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/993

Мандалговь

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хоёр дугаар хавсралтад тусгагдсан “Угийн бичиг хөтлөх аппликешн бүтээх” ажлын 20,000,000 (хорин сая) төгрөгийн төсөл арга хэмжээг Хулд суманд эрх шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн ажлыг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжилтийг олгож, явцын мэдээллийг сар бүрийн 2-ны өдрийн дотор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст тайлагнахыг Хулд сумын Засаг дарга (П.Бямбалхагва)-д даалгасугай

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



4823100762